

ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, ажлын төлөвлөгөө, захиалагч талын өгсөн чиглэл, зааварчилгаа болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны стандарт, дүрэм, журам, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хууль, “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм”, “Тавантолгой” ХК-ийн дүрэм журам, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой ордын уурхайн нүүрс болон хөрсний чулуулагт стандартын шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, дэвшилтэд технологиор тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлыг мэргэжлийн өндөр түвшинд аюул осолгүй бутлан сийрэгжүүлэх ажил хийж гүйцэтгэнэ.

1. ХИЙГДЭХ АЖИЛ

1.1 Тэсэлгээний ажил:

Ордын уул геологийн нөхцөл, чулуулгийн тогтоц, шинж чанараас шалтгаалан хөрсөнд жилийн дөрвөн улирлын турш тэсэлгээний ажлыг явуулна. Нүүрсний хатуулаг нэмэгдэх, бүхэллэгийг багасгах зорилгоор нүүрсэнд тэсэлгээний ажил хийж бутлан сийрэгжүүлнэ:

- 1.1.1. Гүйцэтгэгч нь тэсэлгээний ажлын жишиг төсөл, тухайлан тодорхой нөхцөлд гүйцэтгэдэг тэсэлгээний ажлын төсөл боловсруулж мөрдөж ажиллана. Жишиг төслийг тухайн ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, туршилтын болон үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын үр дүн, шинжлэх ухаан техникийн судалгаа, ижил төстэй нөхцөл дэх үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын туршлага болон “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн шаардлагад үндэслэн боловсруулна.
- 1.1.2. Гүйцэтгэгч нь төсөлд:
 - а) тэсэлгээний ажлын үндсэн хэмжээсүүд;
 - б) цэнэгийг өдөөх арга;
 - в) тэсэлгээний хэлхээний (дараалал, удаашралын хугацаа) тооцоо;
 - г) цэнэгийн бүтэц, бүүстрийн байрлал;
 - д) тэсрэх материалын зарцуулалтын тооцоо;
 - е) тэсэлгээний нөлөөллийн хүрээнд байрлах объектын (барилга, байгууламж, шугам хэлхээ) аюулгүй байдлыг хангах аюултай бүсийн тооцоо, хамгаалах арга;
 - ё) тэсэлгээний бүсийг агааржуулах болон энэхүү дүрэмд заасан аюулгүй ажиллагааны бусад арга хэмжээг зааж, тэсэлгээний ажил болон холбогдох бусад бүхий л шаардлагатай ажлуудыг аюулгүй зохион байгуулах шийдлийг тусгасан байна.
- 1.1.3. Гүйцэтгэгч уурхайд тэсэлгээний ажлыг явуулах ба бутлагдлын дундаж хэмжээг 0.4 метрээс ихгүй болгож бутлан сийрэгжүүлэх үүргийг хүлээнэ;
- 1.1.4. Гүйцэтгэгч нь тэсэлгээний ажлын параметрыг оновчлох, цаашид боловсронгуй болгох зорилгоор тэсэлгээний гүйцэтгэлийн үр дүнг бүртгэж, дүн шинжилгээ хийнэ.
- 1.1.5. Тэсэлгээний ажлаар бутлагдсан чулуулгийн ширхэглэлийн хэвийн бутлагдлын хэмжээ 0.4 метрээс ихсэж овор хэтэрсэн чулуулаг 10%-аас дээш болсон нөхцөлд чанарын шаардлага хангахгүй гэж үзнэ. Шаардлага хангахгүй байгаа гэж үзэж байгаа тэсэлгээний блокт Захиалагч гүйцэтгэгчтэй хамтарсан баг Фотографийн аргаар бутлагдлын шинжилгээ хийж баталгаажуулна. Тус аргаар тогтоогдох боломжгүй блокт техник ажиллуулж тодорхойлно;
- 1.1.6. Тэсэлгээний ажлыг уурхай дээр гүйцэтгэгч нь ажил үүргээ аюул осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах машин тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна. Цооног цэнэглэх ажлыг зөвхөн зориулалтын машинаар хийж гүйцэтгэнэ;
- 1.1.7. Тэсэлгээний ажлаас шалтгаалан нүүрсийг бохирдуулсан тохиолдолд Захиалагч акт үйлдэж, тухайн жилийн хөрс хуулалтын итгэлцүүрийн өссөн дүнгээр тооцон хөрсний хэмжээг гаргаж, хаясан нүүрсийг борлуулах үнээр (тухайн үеийн зах зээлийн үнээр) тооцон Гүйцэтгэгчид төлөх ажлын төлбөрийн гүйцэтгэлээс хасаж тооцно;
- 1.1.8. Гүйцэтгэгч нь уурхай дээр энэхүү техникийн тодорхойлолтод заасан ажлыг хийж гүйцэтгэх хангалттай бүрэлдэхүүн, машин тоног төхөөрөмж бүхий байнгын ажиллагаатай байх ба тэсэлгээний чичирхийллийг хэмжих багаж ашиглана. Тэсэлгээний

чичирхийллийн хэмжилтийг үндэслэн тэсэлгээний бусад параметруудийг тохируулан ашиглана;

- 1.1.9. Төр захиргааны байгууллагаас хяналтын хуудас гаргуулах холбогдох бусад зөвшөөрлийг гүйцэтгэгч тал хариуцна;
- 1.1.10. Хөрсний чулуулаг болон нүүрсийг тэсэлгээний ажлын урьдчилсан төлөвлөгөөг захиалагч талаас сар, жилээр нэгтгэж гаргана. Тухайн сарын төлөвлөгөөг сар эхлэхэд захиалагч тал боловсруулж баталсан байна. Гүйцэтгэгч тал нь төлөвлөгөөт сарын техникийн бэлэн байдлыг өмнөх сарын 25-ны өдөр ирүүлсэн байна;
- 1.1.11. Хөрсний чулуулаг тэслэх тэсрэх бодисын дундаж хувийн зарцуулалт нь $0.33-0.48 \text{ кг/м}^3$ хооронд, нүүрс тэслэх тэсрэх бодисын дундаж хувийн зарцуулалт нь $0.15-0.3 \text{ кг/м}^3$ хооронд тус тус хэрэглэхээр төлөвлөнө. Устай цооногт хэрэглэх эмульсийн тэсрэх бодис нь нийт тэслэгдэх хөрсний 85% байна;
- 1.1.12. Хөрсний чулуулгийн бутлагдлын чанарыг сайжруулах, чулуулгийн шилжилт, хөрсний тархалтыг багасгах, тэсэлгээний улмаас гарах аюул, ослыг багасгахын тулд тэсэлгээний хэрэгслийг хором удаашруулсан үйлчилгээтэй чанар сайтай тэсрэх бодис, үйлдвэрийн алдаа багатай тэслэх хэрэгслийг сонгон ажиллана;
- 1.1.13. Тэслэгдсэн уулын цулын нөөц 1 сараас багагүй, тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн нөөц 1 сараас багагүй байлгахад хангаж ажиллах ба нөөцийн мэдээллийг Захиалагчид сар бүрийн 25-ны өдөр нотлох баримтын хамт ирүүлнэ;
- 1.1.14. Захиалагч талын тэсэлгээний ажлын төлөвлөгөө, тооцоонд ашиглаж буй программ хангамжийн ашиглалт, практик ач холбогдлыг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана;
- 1.1.15. Цанхийн уурхайн тэсэлгээний ажлын тооцоо, чулуулгийн бутлагдлын хэмжээг оновчлох, конвейерийн туузын өргөнөөр хязгаарлагдах нөхцөлөөр цооногийн диаметр, цооног болон эгнээ хоорондын зайг тодорхойлох гэх мэт судалгааны ажилд санаачилга гаргах, захиалагч талтай хамтран ажиллана;
- 1.1.16. Уурхайн бусад хэсэгт хөрсний чулуулаг болон нүүрсийг тэсэлгээний ажил гүйцэтгэж буй гэрээт компанийн техникийн бэлэн байдал буурах, уурхайн технологийг алдагдуулахгүй байх зэргээс шалтгаалан захиалагчийн саналаар гэрээнд заах үнийн дүнгээр хөрвүүлэн ажиллуулж болно;
- 1.1.17. Тэсэлгээний ажилд шаардлагатай түгжээсний хайргыг Захиалагч хангаж болох бөгөөд төлбөрийг зах зээлийн ханшаар тохиролцоно;
- 1.1.18. Үйл ажиллагаатай холбоотой ажлын хэмжээ, хайрга, дайрга, тэсрэх бодис, техник, тоног төхөөрөмжүүдийн өртөг зардалтай холбоотой бүхий л төрлийн мэдээллийг Захиалагчаас шаардсан хэлбэр, цаг хугацаанд үнэн, зөв байдлаар нотлох баримтын хамт гаргаж өгнө;
- 1.1.19. Уурхайн ханын тогтворжилтыг хангах зорилготой хүрээ гаргах тэсэлгээ болон шинэ дэвшилтэт технологи, аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж ажиллана;
- 1.1.20. Тэсэлгээний ямар нэгэн блок хугацаа хоцорсноос болж Захиалагчийн болон гэрээт олборлогчийн ажил саатах, шаардлагатай хэмжээний нүүрс нээх боломжийг алдсан нөхцөлд тухайн сарын KPI үнэлгээний үйлдвэрлэлийн оноог '0' гэж дүгнэж гэрээнд заасны дагуу төлбөрөөс суутгана;
- 1.1.21. Ажлын бус тал болон тэсэлгээний ажлын технологийн дагуу уурхайн хүрээнд хэтэрсэн догол, хананы улны үлдэгдэл хөрсийг тэсэрсэн хөрсний үлдэгдэлд тооцохгүй;
- 1.1.22. Тэсрэх бодисын чанар олон улсын стандартад нийцсэн тэсрэх бодисын түүхий эд, орц найрлага нь чулуулгийг бутлан сийрэгжүүлэх чадалтай лабораториор туршигдан баталгаажсан байна.

1.2. Инженерийн ажил

Захиалагчийн шаардлагын дагуу тухайн сард гүйцэтгэх тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх, шаардлагатай бусад ажлын 0.5 хувьд ноогдох хэмжээтэй бүтээлийн бус инженерийн ажлыг сар, долоо хоногийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ. Тухайн сард хийгдээгүй инженерийн ажлыг хуримтлагдсан дүнгээр жилийн хэмжээнд тооцон хийж болно.

1.3. Байгаль орчин, усны бодлого, орчны хамгаалал, нөхөн сэргээлт:

- 1.3.1. Гүйцэтгэгч нь байгаль орчин, усны бодлого хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу гэрээт компанийн хүлээх үүргийг Захиалагчаас баталсан хуваарийн дагуу биелүүлж,

биелэлтийг захиалагчид улирал бүр тайлагнана; Захиалагчаас батлах төлөвлөгөөнд тайлагнах хуваарийн өдөр, хугацааг заана.

- 1.3.2. Тэсэлгээний үйл ажиллагаанаас үүссэн хий, хатуу, шингэн хог хаягдлыг Монгол Улсын хууль, журам, стандарт болон захиалагчийн дотоод журмын дагуу төвлөрүүлэх, зайлуулах, аюултай хог хаягдлыг устгах буюу саармагжуулах, хог хаягдлын стандарт байгууламжийг барих, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх цогц арга хэмжээг тусгасан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан захиалагчаар хянуулан батлуулж гэрээт хугацаанд буюу тухайн жилдээ төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана;
- 1.3.3. Үйл ажиллагааны явцад эвдэрсэн, доройтсон, бохирдсон газар болон хог хаягдлын түр цэгт техникийн нөхөн сэргээлт хийн бохирдлыг арилгаж, ажил дуусгавар болоход захиалагчид хүлээлгэж өгнө;
- 1.3.4. Ажлыг гүйцэтгэх үедээ нийтийн зам талбай, байгууламжид чулуу, шороо, барилгын материалын үлдэгдэл зэрэг хог хаягдал хаяхгүй цэвэр цэмцгэр байлгах, орчин тойрныг бохирдуулахгүй, хаягдсан хог материалыг бүрэн цэвэрлэж, орчны хэвийн нөхцөлийг тухайн ажлын өдөрт нь сэргээж, цэвэрлэж байна;
- 1.3.5. Байгаль орчны чиглэлээр хийгдэх ажилд техник тоног төхөөрөмжийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ;
- 1.3.6. Гэрээний дагуу уулын ажилд өртсөн, ашигласан бүхий л газар, талбайд нөхөн сэргээлт хийж захиалагчид хүлээлгэж өгнө.
- 1.3.7. Монгол Улсад мөрдөгдөж байгаа Байгаль орчны багц хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм журмыг мөрдөх, MNS 5914:2008, MNS 5915:2008, MNS 5917:2008 стандартын дагуу эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, ургамалжуулалтыг хийх;

1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй:

- 1.4.1. Тэсэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн системийг боловсруулан, захиалагчаар батлуулж, гэрээт хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана;
- 1.4.2. Уурхайн технологийн ажлуудад зориулан аюулгүй ажиллагааны журам, горим боловсруулан Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай эрсдэлийн үнэлгээг хийсэн байна. Мөн үйл ажиллагаандаа MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлж ажиллах бөгөөд шаардлагатай ажлууд дээр дутуу дүрэм журмыг боловсруулан захиалагчаар батлуулж, мөрдөж ажиллана;
- 1.4.3. Ажлын гүйцэтгэлийн явцад гарсан технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдол гарсан тохиолдолд захиалагч талд мэдэгдсэний дагуу заасан хугацаанд арга хэмжээ авч, үр дүнг захиалагч талд танилцуулж, зөвшөөрөл авсны дараагаар хэвийн үйл ажиллагааг эхэлнэ;
- 1.4.4. Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, усны бодлогын /Цаашид ХАБЭА, БОУБ гэх/ ажилтнуудтай хамтран ажиллаж, тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй;
- 1.4.5. ХАБЭА, БОУБ-ны талаарх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй;
- 1.4.6. ХАБЭА, БОУБ-той холбоотой аливаа зөрчил дутагдал гарсан болон цаашилбал хүний амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болохуйц аюул, эрсдэлтэй нөхцөл аль нэг ажлын байр болон үйл ажиллагаанд үүссэн тохиолдолд талууд оролцож тэмдэглэл үйлдэн тухайн ажлыг зогсооно.
- 1.4.7. Гүйцэтгэгч нь үүссэн аюул эрсдэлтэй ажлын байр болон нөхцөлийг бүх ажлын байруудад арилгасны дараа үйл ажиллагааг захиалагчийн зөвшөөрлөөр эхлүүлнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүй буюу засаж залруулах арга хэмжээг хангалтгүй авсан үед үйл ажиллагаагаа дур мэдэн эхлүүлсэн эхний тохиолдолд ХАБЭА, БОУБ-ны гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн ХАБ-ын хэсэгт харгалзах хувийг бүхлээр нь; 2 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд тухайн сарын гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн ХАБЭА, БОУБ хэсэгт харгалзах оноог бүхлээр нь шууд хасах; 3 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна;

- 1.4.8. ХАБЭА, БОУБ-ны гүйцэтгэлийг жил болон сараар дүгнэх, уг дүгнэлтийг сар бүрийн төлбөртэй хэрхэн уялдуулж тооцоолох Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг гэрээнд нарийвчлан тусгана;
- 1.4.9. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн, тусгагдсан ажлуудыг дэмжиж ажиллана.

1.5. Тэсэлгээний ажлын гүйцэтгэх үнэлгээ:

- 1.5.1. Уурхайн бүсэд хамаарах тэсэлгээний ажлыг гүйцэтгэх нийт болон нэгжийн үнэлгээг төгрөг/м³-ээр тооцож ирүүлнэ;
- 1.5.2. Захиалагч нь ажлын гүйцэтгэлийн төлбөрийг гүйцэтгэгч талд төгрөгөөр төлнө.

1.6. Ажлын даалгаврын хавсралт

1.6.1. Хавсралт зургууд:

- Зураг№1. Хөрсний доголын тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлын паспорт
- Зураг№2. Жилийн эцсийн хананы тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлын паспорт
- Зураг№3. Нүүрсний доголд хийх тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлын паспорт

1.6.2. Хавсралт хүснэгтүүд:

- Хүснэгт №1. Тэслэх уулын цулын хэмжээ
- Хүснэгт №2. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн ажлын үзүүлэлт
- Хүснэгт №3. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн жагсаалт

2. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Ерөнхий:

- 2.1.1. Гүйцэтгэгч нь 3-аас доошгүй жил уул уурхайн салбарт үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, тэсэлгээний ажил, үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх;
- 2.1.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй байх;
- 2.1.3. Гүйцэтгэгчийн баг бүрэлдэхүүн нь ажил үүргээ аюул, осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах машин, тоног төхөөрөмж, ажлын багаж, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан байх;
- 2.1.4. Цаг ашиглалт болон техникийн бэлэн байдлыг 85-аас доошгүй хувьтай байх;
- 2.1.5. Тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлыг өгөгдсөн хуваарийн дагуу саадгүй хийж гүйцэтгэхэд шаардлагатай доорх асуудлуудыг бүрэн шийдвэрлэх чадамжтай байх;
- Сард 2000 тн-с багагүй хүчин чадалтай эмульсийн тэсрэх бодисын өөрийн үйлдвэртэй байх, эсхүл хамтран ажиллах гэрээтэй байх;
 - Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй хангах тэсрэх хэрэгсэл, тэсрэх бодисын гол түүхий эдийн агуулахтай байх, эсхүл хамтран ажиллах гэрээтэй байх;
- 2.1.6. Гүйцэтгэгч нь “Тавантолгой” ХК-ийн уурхайд тэсэлгээний ажлын үзүүлэлттэй уялдуулан батлагдсан паспортын дагуу тэсэлгээний цооног бэлтгэх ажлыг гүйцэтгэнэ. Уг ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмжтэй байх;
- 2.1.7. Нүүрсний давхраасны тааз, уланд бэлтгэсэн тэсэлгээний цооногийн мэдээллийг захиалагч талд цаг тухай бүр хүлээлгэн өгөх.

2.2. Хүн хүч:

- 2.2.1. Гүйцэтгэгч нь хүснэгт №1-д заасан тэсэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай. Уул уурхайн чиглэлийн мэргэжлийн их сургуулийн зохион байгуулсан сургалтад бүрэн хамрагдаж, хөтөлбөрт хичээлийг судалсны үндсэн дээр мэргэжлийн шалгалтын комисст шалгалт өгч тэнцсэн, хүчин төгөлдөр тэсэлгээчний нэгдсэн болон харьцах эрхийн үнэмлэх бүхий инженер техникийн ажилчдын баг бүрэлдэхүүнтэй байна. Гүйцэтгэгч нь ажил эхлэх үед дараах мэргэжлийн баг, ажиллах хүний нөөцөөр бүрэн хангагдсан байна.

№	Мэргэжил	Тоо
1	Тэсэлгээний удирдагч	4
2	Тэсэлгээчин	4

2.3. Тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажилд ашиглагдах техник хэрэгсэл, машин механизм:

Гүйцэтгэгч нь хүснэгт №2-д заасан тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлыг гүйцэтгэх шаардлагатай техник хэрэгсэл, машин механизмаар бүрэн хангагдсан байна.

- 2.3.1. Уулын ажлын төлөвлөгөө, зураг төсөл, уурхайн уулын ажлын горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажил хийх хангалттай хүчин чадалтай, иж бүрэн үндсэн тоног төхөөрөмжүүдтэй байна.
- 2.3.2. Уурхайд ажиллах техник, тоног төхөөрөмжүүдийн тоо, бүтээл, ашиглалтанд орсон огноо, техникийн бэлэн байдал зэрэг бусад нарийвчилсан үзүүлэлтүүдийг харуулсан дэлгэрэнгүй мэдээлэлтэй байна.
- 2.3.3. Үндсэн болон туслах техник, тоног төхөөрөмж:

Шаардлагатай тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоо хэмжээ
<ul style="list-style-type: none"> Тэсэлгээний хуурай цооног цэнэглэх 3 машин, устай цооног цэнэглэх 4 машинтай байх, эсхүл хуурай болон устай цооног цэнэглэх давхар үйлдэлтэй зориулалтын 4 машинтай байх. (өөрийн эзэмшлийн байна.); Тэсэлгээний цооног бэлтгэх машин: 165(±20) мм өрмийн хошуутай хошуутай 4- өөс багагүй байх; Шаардлагатай тохиолдолд тэсэлгээний цооног бэлтгэх машины тоо хэмжээг нэмж ажиллуулах боломжтой байх;
Бусад туслах техникүүд
<p>Доорх техникүүд нь түрээсийн болон бусад гэрээтэй байж болох бөгөөд ажил эхлүүлэх үед уурхайн талбайд бэлэн байлгана.</p> <ul style="list-style-type: none"> Түгжигч машин ажиллуулна. Гэрэлт цамхаг 6-аас доошгүй байрлуулна.

- 2.3.4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу техник, тоног төхөөрөмжийн хувьд холбогдох хүчин төгөлдөр зөвшөөрөл, шаардлагыг хавсарган ирүүлнэ.

3. БУСАД ШААРДЛАГА

- 3.1. Уулын ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай аливаа тусгай зөвшөөрөл авах, сум орон нутагтай гэрээ байгуулах, орон нутгийн засаг захиргаанаас тушаал шийдвэр гаргуулах, газар ус болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл авах зэрэг асуудлыг Гүйцэтгэгч тал өөрөө хариуцах бөгөөд ийнхүү хийгээгүйгээс гарсан аливаа хохирлыг Захиалагч тал болон бусад талууд хариуцахгүй.
- 3.2. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил /KPI/-ыг дараах байдлаар үнэлж оноо өгнө.
- Гэрээний үүргийн хэрэгжилт (10 оноо)
 - Үйлдвэрлэл, технологи (50 оноо)
 - Нүүрсний чанар (20 оноо)
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (10 оноо).
 - Байгаль орчин (10 оноо).
- 3.3. Тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнг доор дурдсан шатлалаар үржүүлэн нийт төлбөрөөс хасаж тооцно. Үүнд:
- 89.9-85 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.01%-иар,
 - 84.9-80 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.02%-иар,

- 79.9-75 оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.03%-иар,
 - 74.9 буюу түүнээс доош оноогоор үнэлэгдсэн бол тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын мөнгөн дүнгийн 0.05%-иар тус тус тооцно.
- 3.4. Гүйцэтгэгчийг үнэлэх дээрх үзүүлэлтийг гэрээний шатанд нарийвчлан зааж өгнө.
 - 3.5. Гэрээний хугацаанд 3 удаа /сар/ KPI онооны нийлбэр 70 хувиас доош орсон тохиолдолд гэрээг цуцална.
 - 3.6. Гүйцэтгэгч нь Төслийн удирдлагын багийн гүйцэтгэл дүгнэх хурлаас өгсөн хугацаат үүрэг даалгаврыг заасан хугацаанд хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлээгүй тохиолдолд KPI онооноос хасна.
 - 3.7. Гүйцэтгэгч нь Төслийн удирдлагын багийн гүйцэтгэл дүгнэх хуралд ажлын тайланг танилцуулах бөгөөд хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажлын нэгж өртөг, түлш зарцуулалт, ашигласан тэсрэх бодисын түүхий эдийн болон тэслэх хэрэгслийн хэмжээ, хайрга, дайрганы хэмжээ, тоног төхөөрөмжүүдийн гүйцэтгэлүүдийг холбогдох нотлох баримтуудын хамт тайланд багтаасан байх ба дараа сарын 03-ны өдрөөс өмнө Захиалагчид ирүүлсэн байна. Тайлангийн чанар, бэлтгэсэн байдал, мэдээлэл зэрэг нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй тохиолдолд тайланг буцааж, гүйцэтгэл дүгнэх хурлыг 5 хүртэлх хоногоор хойшлуулж болно.
 - 3.8. Захиалагч гэрээний дүгнэлт танилцуулах, Гүйцэтгэгчийн тайлантай танилцах хурлыг төслийн удирдлагын багийн дарга дараа сарын 10-ны дотор товлон зарлаж хуралдуулна.
 - 3.9. Гүйцэтгэгч нь ажлын даалгаварт заасан техник хэрэгсэл, машин механизм болон дэд бүтцийн барилга байгууламжийг заасан хэмжээ, үзүүлэлтийн дагуу уурхайд бэлэн байлгах бөгөөд холбогдох нотлох баримтуудыг сар бүр Захиалагчид хүргүүлнэ.
 - 3.10. Гүйцэтгэгч нь 30-с багагүй хоног ажил гүйцэтгэхэд шаардлагатай тэсрэх бодисын түүхий эд, тэслэх хэрэгслийн нөөцтэй байх бөгөөд холбогдох нотлох баримтуудыг сар бүрийн 25-ны өдөр Захиалагчид хүргүүлнэ.
 - 3.11. Захиалагч нь 7-оос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэний дүнд тэсэлгээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд сул зогсолт хийлгэж болно. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.
 - 3.12. Тавантолгой ХК-ийн уурхайд ажиллаж буй техник, тоног төхөөрөмжүүд ажлын талбайд багталцахгүй байх, бусад асуудлаас шалтгаалан техникүүд ажиллаагүй тохиолдолд захиалагч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.
 - 3.13. Давагдашгүй хүчин зүйл (Засгийн газрын шийдвэр, хууль тогтоомжийн өөрчлөлт, ажил хаялт, эдийн засгийн хямрал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр, үер усны гамшиг болон бусад байгалийн гамшигт үзэгдэл, гадаад худалдааны хорио цээр болон экспорт, импортын хориг, терроризм болон цар тахал)- ийн улмаас төлөвлөгөөт ажлыг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.
 - 3.14. Тавантолгой ХК-ийн уурхайн уулын ажлын технологийн удирдлагыг боловсронгуй болгох, уурхайн хяналт, нэгдсэн системийг Захиалагч нэвтрүүлж байгаатай холбоотойгоор Гүйцэтгэгч нь дэмжиж, хамтран ажиллана.
 - 3.15. Гүйцэтгэгч нь тендэрт ирүүлсэн машин, тоног төхөөрөмж, ажиллах хүчийг зөвхөн энэ гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд ашиглаж, бэлэн байдлыг хангаж ажиллана.

4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ

Тэслэх уулын цулын хэмжээ

Хүснэгт №1

Жил	Хэмжих нэгж	Уулын цул	Инженерийн ажил
2024 (8 сар)	м ³	26,258,159	131,291
2025 (12 сар)	м ³	39,387,237	196,936
2026 (4 сар)	м ³	13,129,079	65,645
Дүн	м³	78,774,475	393,872

Уулын ажлын хэмжээ нь ажил эхлэх эхний сард бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэмжээг

бууруулах, тухайн жилийн тухайн сарын онцлогт нь тохируулж, нүүрсний эрэлт нийлүүлэлтээс хамааран нэмэх, хасах зэргээр хэлбэлзэнэ. Иймд дээрх ажлын хэмжээг Захиалагчийн төрийн эрх бүхий байгууллагаар батлуулсан тухайн оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр өөрчилж болох бөгөөд тухайн жил, сар, долоо хоногийн төлөвлөгөө мөн Захиалагч шаардлагатай гэж үзсэн үедээ өөрчилж болно.

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн ажлын үзүүлэлт

Хүснэгт №2

Д/д	Үзүүлэлт		Хөрсний өрөмдлөг, тэсэлгээ	Нүүрсний өрөмдлөг, тэсэлгээ	Ул талбайд	Бусад хэсэгт
	Ажиллах байршил					
1						
2	Техник, Тоног төхөөрөмжийн нэр	Өрмийн машин	Загвар			
3		Цэнэглэлтийн машин				
4		Түгжээсний машин				
5		Гэрэлт цамхаг				


Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн жагсаалт

Хүснэгт №3


Дд	Тоног төхөөрөмжийн нэр			Хүчин чадал багтаамж		Өмчлөлийн хэлбэр	Ашиглалтын хугацаа			Түлш зарцуулалт			Техникийн бэлэн байдал %	Тайлбар
	Төрөл	Загвар	Үйлдвэрлэсэн улс	Нэгж	Хэмжээ		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад өгсөн он	Ашиглалтын хугацаа	Хэмжих нэгж (л/мот.цаг)	Нийт ажилласан мот.цаг	Нийт зарцуулсан түлшний хэмжээ		
	Тэсэгэн													
	ий цооног													
	бэлтгэх													
	машин													
	Цэнэглэлт													
	ийн													
	Түгжээ													
	сний													
	Гэрэлт													
	цамхаг													

Жич: Тоног төхөөрөмжүүдийн цаг ашиглалт болон техникийн бэлэн байдлыг 85- аас доошгүй хувьтай байлгана. Ирүүлсэн жагсаалтын дагуу "Тавантолгой" ХК-ийн техникийн комисс тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдлыг шалгана.

Зураг №1. Хөрсний доголын тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлын паспорт



Зураг№2. Жилийн эцсийн хананы тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлын паспорт



Зураг№3. Нүүрсний доголд хийх тэсэлгээний болон тэсэлгээний цооног бэлтгэх ажлын паспорт

